



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ОРА-2021/75/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Аудитор: Т.Болормаа

Утас: 70357955 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	Error! Bookmark not defined.
4. Менежментийн захидал	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	Error! Bookmark not defined.

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

СОР. ОР. 25 № 28
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН НОМЫН
ТӨВИЙН ДАРГА А.УРАНЧИМЭГ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн номын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн номын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,257,122.00</u>	<u>6,238,122.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,926,222.00	2,396,222.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,926,222.00	2,396,222.00
31130	Нэмэлт санхүүжилт	3,926,222.00	2,396,222.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,330,900.00	3,841,900.00
351	Түүхий эд материал	2,151,200.00	3,662,200.00
35110	Тусгай зориулалттай материал	2,151,200.00	3,662,200.00
354	Хангамжийн материал	179,700.00	179,700.00
35420	Аж ахуйн материал	179,700.00	179,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>967,528,662.78</u>	<u>948,465,014.15</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	967,528,662.78	948,465,014.15
392	Биет хөрөнгө	850,618,662.78	831,630,014.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	690,634,289.00	690,634,289.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,076,174.05)	(36,819,478.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	21,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,000,000.00)	(21,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,165,372.00	58,165,372.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(47,065,769.80)	(51,964,937.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,613,122.52	37,613,122.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,752,684.89)	(31,789,710.01)
39217	Ном	158,100,508.00	165,791,356.00
393	Биет бус хөрөнгө	116,910,000.00	116,835,000.00
39301	Програм хангамж	6,180,000.00	6,180,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(5,880,000.00)	(5,955,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	116,610,000.00	116,610,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>973,785,784.78</u>	<u>954,703,136.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>973,785,784.78</u>	<u>954,703,136.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	973,785,784.78	954,703,136.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	370,872,729.52	370,872,729.52
512	Хуримтлагдсан үр дүн	169,389,360.74	150,306,712.11
51210	Өмнөх үеийн үр дүн	155,983,655.53	169,389,360.74
51220	Тайлант үеийн үр дүн	13,405,705.21	(19,082,648.63)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	433,523,694.52	433,523,694.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>973,785,784.78</u>	<u>954,703,136.15</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	424,083,230.00	357,410,068.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,462,608.00	6,224,468.00
120	Нийтлэг татварын бус орлого	46,550,864.00	3,995,620.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	46,388,864.00	3,995,620.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,591,420.00	3,966,120.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,694,840.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,102,604.00	29,500.00
120009	Бусад орлого	162,000.00	-
122	Тусламжийн орлого	-	2,228,848.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	2,228,848.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	32,911,744.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	32,911,744.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	344,620,622.00	351,185,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	65,614,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	65,614,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,926,222.00	-
131106	Төсвийн урамшуулал	3,926,222.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	275,080,200.00	351,185,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	266,694,200.00	346,185,600.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	8,386,000.00	5,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	312,151,580.79	376,492,716.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,151,580.79	376,492,716.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	291,274,913.47	309,054,361.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,409,509.00	222,472,013.00
210101	Үндсэн цалин	113,965,876.00	53,444,492.00
210102	Нэмэгдэл	67,447,033.00	154,220,121.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,996,600.00	14,807,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,920,138.91	28,395,981.27
210201	Тэтгэврийн даатгал	16,316,894.11	19,504,145.19
210202	Тэтгэмжийн даатгал	1,900,811.20	2,222,959.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,520,648.97	1,778,367.22
210204	Ажилгүйдлийн даатгал	380,162.23	444,591.80
210205	Эрүүл мэндийн даатгал	3,801,622.40	4,445,918.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,100,791.00	21,227,561.00
210301	Гэрэл, цахилгаан	3,749,359.00	3,558,615.00
210302	Түлш, халаалт	13,079,803.00	14,903,946.00
210303	Цэвэр, бохир ус	2,321,629.00	2,765,000.00
210304	Байрны түрээс	1,950,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,491,695.00	3,368,860.00

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	1,740,450.00	1,075,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,645.00	1,417,760.00
210404	Ном, хэвлэл	39,600.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	580,000.00	29,500.00
2105	Нормативт зардал	375,490.00	851,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	475,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	375,490.00	375,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,453,100.00	1,223,900.00
210604	Урсгал засвар	7,453,100.00	1,223,900.00
2107	Томилолт, зочны зардал	324,600.00	297,600.00
210702	Дотоод албан томилолт	324,600.00	297,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,477,630.00	4,462,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	4,316,000.00
210807	Газрын төлбөр	966,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	311,630.00	146,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,721,959.56	26,754,496.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,440,261.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,281,698.56	26,754,496.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,876,667.32	67,438,354.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	960,840.00	55,312,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,082,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,840.00	3,230,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,915,827.32	12,125,854.73
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,915,827.32	12,125,854.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>111,931,649.21</u>	<u>(19,082,648.63)</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>111,931,649.21</u>	<u>(19,082,648.63)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	357,680,482.00	356,531,720.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,448,260.00	3,966,120.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,448,260.00	3,966,120.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,286,260.00	3,966,120.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,591,420.00	3,966,120.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,694,840.00	-
120009	Бусад орлого	162,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	345,232,222.00	352,565,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	65,614,200.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	65,614,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,926,222.00	-
131106	Төсвийн урамшуулал	3,926,222.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	275,080,200.00	351,185,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	266,694,200.00	346,185,600.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	8,386,000.00	5,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	611,600.00	1,380,000.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	611,600.00	1,380,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	284,766,560.00	352,599,720.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,766,560.00	352,599,720.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263,278,292.68	283,781,365.27
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	194,658,048.77	222,722,994.27
210101	Үндсэн цалин	156,299,148.77	167,046,275.00
210102	Нэмэгдэл	22,482,900.00	46,410,636.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,876,000.00	9,266,082.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,920,137.91	28,145,000.00
210201	Тэтгэврийн даатгал	16,686,400.00	19,138,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,963,100.00	2,251,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,570,500.00	1,801,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	263,700.00	450,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,436,437.91	4,503,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,100,791.00	21,227,561.00
210301	Гэрэл, цахилгаан	3,749,359.00	3,558,615.00
210302	Түлш, халаалт	13,079,803.00	14,903,946.00
210303	Цэвэр, бохир ус	2,321,629.00	2,765,000.00
210304	Байрны түрээс	1,950,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	4,552,495.00	4,321,160.00
210401	Бичиг хэрэг	1,426,250.00	1,075,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	750,000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	835,645.00	1,417,760.00
210404	Ном, хэвлэл	994,600.00	906,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	171,800.00
2105	Нормативт зардал	375,490.00	775,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	375,490.00	375,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,003,100.00	1,828,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,550,000.00	685,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	500,000.00
210604	Урсгал засвар	7,453,100.00	643,900.00
2107	Томилолт, зочны зардал	324,600.00	297,600.00
210702	Дотоод албан томилолт	324,600.00	297,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,477,630.00	4,462,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	3,350,000.00
210807	Газрын төлбөр	966,000.00	966,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	311,630.00	146,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,866,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,866,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,488,267.32	68,818,354.73
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,572,440.00	56,692,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	611,600.00	1,380,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	52,082,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	960,840.00	3,230,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	19,915,827.32	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,915,827.32	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	12,125,854.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	12,125,854.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>72,913,922.00</u>	<u>3,932,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>4,923,500.00</u>	<u>5,462,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>4,923,500.00</u>	<u>5,462,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	4,923,500.00	5,462,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,923,500.00	5,462,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(4,923,500.00)</u>	<u>(5,462,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	67,990,422.00	(1,530,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(64,064,200.00)	3,926,222.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,926,222.00	2,396,222.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	155,983,655.53	960,380,079.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	155,983,655.53	960,380,079.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	13,405,705.21	13,405,705.21
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	169,389,360.74	973,785,784.78
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	169,389,360.74	973,785,784.78
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	169,389,360.74	973,785,784.78
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(19,082,648.63)	(19,082,648.63)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	370,872,729.52	433,523,694.52	150,306,712.11	954,703,136.15

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Орхон аймгийн Номын төвийн дарга А.Уранчимэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 сарын 22-ний өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Орхон аймгийн Номын төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Номын сангийн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй иргэнийг төлөвшүүлэхэд оршино.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Орхон аймгийн Номын төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 206,053.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,060.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 357,410.1 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3,574.1 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчилсөн.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,063.7 мянган төгрөгөөр буюу 1.95 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,926.20	2,396.20	-1,530.00
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,330.90	3,841.90	1,511.00
Үндсэн хөрөнгө	967,528.70	948,465.00	-19,063.70
Нийт хөрөнгө	973,785.80	954,703.10	-19,082.70
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	370,872.70	370,872.70	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	973,785.80	954,703.10	-19,082.70

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,396.2 мянган төгрөг болж 1,530.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангаас ахмадын баяраар тэтгэмж олгосноос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,841.9 мянган төгрөг болж 1,511.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 948,465.0 мянган төгрөг болж 19,063.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардал 26,754.5 мянган төгрөг бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь худалдаж авсан 5,462.0 мянга, хандиваар 2,228.8 мянган төгрөг, нийт 7,690.8 мянган төгрөгийн номын фонд нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн, акталсан хөрөнгө тайлант онд бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 370,872.7 мянган төгрөгт тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Орхон аймгийн Номын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 66,673.2 мянган төгрөгөөр буюу 15.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 34,073.1 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас 32,911.7 мянган төгрөгийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 64,341.1 мянган төгрөгөөр буюу 20.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал шилжүүлгийн зардлууд байна. Энэ нь ажилтнуудаас 3 ажилтан тэтгэвэрт гарсны тэтгэмж 52,082.5 мянган төгрөгийг олгосноос шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 376,394.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 376,394.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 30,208.6 мянган төгрөгөөр бууруулж 346,185.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төсөл болон өмнөх оны баталсан төсвөөс материаллаг өөрчлөлттэй нь хангамж, бараа материалын зардлыг 6,851.3 мянга, тогтмол зардлыг 8,858.4 мянга, эд хогшил худалдан авах 1,544.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 1,199.7 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,500.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 346,185.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 346,185.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 346,185.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 334,084.1 мянган төгрөгийг зарцуулж, 12,101.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 334,084.1 мянган төгрөг буюу 96.47 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 2,437.0 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 4,485.2 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 3,545.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 1,244.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 3,928.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын төсөл хөтөлбөрөөс 5,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,140.9 мянга, түрээсийн төлбөрийн 40%-ийн орлого 1,825.2 мянга нийт 8,966.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамжийн бараа материалд 1,036.8 мянга, эм бэлдмэлд 400.0 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 955.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 3,350.0 мянга, хөрөнгө бэлтгэхэд 2,000.0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 1,200.0 мянга нийт 8,941.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 24.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна.

Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн тул зөвлөмжийн хэрэгжилт бүртгэгдээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 52,527.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 53.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 139.9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 52,333.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн төвлөрүүлэх шилжүүлэг 24.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.
2. Бараа материалд 29.5 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн орлогыг бараа материалын дэлгэрэнгүй тайланд буруу бүртгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 52,473.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 139.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Байгууллагын дарга нь улирал бүр үр дүнгийн урамшуулал авахдаа Засгийн газраас тогтоосон хэмжээнээс үндсэн цалингийн 5% буюу 46.6 мянган төгрөг, нийт 139.9 мянган төгрөгийг илүү бодож олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", 51.2-т "..... 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгох журмыг Засгийн газар,батална", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна" заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 52,333.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Орхон аймгийн Номын төвийн мөнгөн кассын ажиллагаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Цалингийн зардлаас гүйлгэн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 250.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- 1.2. Эрсдэл: Бүлэг хооронд гүйлгэн зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулан
- 1.3. Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт багтаан эдийн засгийн ангиллын дагуу гүйлгээр хийж, хянаж байх
- 1.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн Номын төвийн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 17 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй, шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасны дагуу 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.

2.2. Эрсдэл: Ашиг сонирхлын зөрчил үүсэх

2.3. Өгсөн зөвлөмж: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэр гаргахдаа ашиг сонирхлын мэдүүлэг гаргаж, баталгаажуулж, шилэн дансанд мэдээлж байх.

2.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Орхон аймгийн Номын төвийн 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 17 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ХЯНАСАН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Ц.НАРМАНДАХ



ОРА-2021/75/СТА-ТШЗ

14

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

АУДИТЫН МЕНЕЖЕР:  Б.ЭРДЭНЭ

БЭЛТГЭСЭН:
АУДИТОР:  Т.БОЛОРМАА

Орхон аймгийн Номын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Орхон аймгийн Номын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ОРА-2021/75/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймгийн Номын төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын дарга нь улирал бүр үр дүнгийн урамшуулал авахдаа Засгийн газраас тогтоосон хэмжээнээс үндсэн цалингийн 5% буюу 46.6 мянган төгрөг, нийт 139.9 мянган төгрөгийг илүү бодож олгосон	139.9	Төлбөрийн акт	Дарга, нягтлан бодогч	А.Уранчимэг, Ш.Болдбаатар
2	Цалингийн зардлаас гүйлгэн нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 250.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.	250.9	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	А.Уранчимэг, Ш.Болдбаатар
3	Шилэн дансны мэдээлэл Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д "Энэ хуулийн 23.8-д заасан журамд заасны дагуу албан тушаалтан захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана" гэж заасны дагуу тушаал шийдвэр өмч хөрөнгө захиран зарцуулахтай холбоотой шийдвэрт ашиг сонирхлын мэдүүлэг гаргаагүй, шилэн дансны тухай хуулийн 6.4.5-д заасны дагуу 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 3 зарлагын гүйлгээг мэдээлээгүй байна.	52,082.5	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	А.Уранчимэг, Ш.Болдбаатар
ДҮН		52,473.3			

АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛИЙГ

ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Ц.НАРМАНДАХ
 АУДИТЫН МЕНЕЖЕР: Б.ЭРДЭНЭ
 БЭЛТГЭСЭН:
 АУДИТОР: Т.БОЛОРМАА

ОРА-2021/75/СТА-ТШЗ

16

